

ТАНАЙ ХҮҮХЭД АНХ УДАА- ГАА ЧЕХ УЛСАД СУР- ГУУЛЬД ОРЖ БАЙНА УУ? ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЭЛ



Чех улсад сургууль болон эцэг эхчүүдийн хоорондхи хамтран ажиллагаа нь маш чухал билээ. Сургууль эцэг эхчүүдийг хүүхдүүддээ хичээлд нь тусалж багш нартай тогтмол хамтран ажиллана гэж хүлээж буй. Мөн хүүхдүүдийн сурлага нь эцэг эхээс шалтгаалах учраас аливаа асуудлыг тэд бүхэнтэй хамтран шийдвэрлэнэ гэж үздэг.

СУРГУУЛЬТАЙ ХЭРХЭН ШИЛДЭГЭЭР ХАРИЛЦАХ ВЭ?

- Та хүүхдээ сургуульд ормогц аливаа асуудал гарсан тохиолдолд холбоо барих хүнээ сонгож, хэнийг гол холбоо барих хүнээрээ сонгосоноо сургуулийн захиралтай тохиролцоно уу (ангийн багш, хүмүүжүүлэгч, урьдчилан сэргийлэх аргын болон бусад боловсролын ажилтан)
- Гол холбоо барих хүнийхээ нэр, овог, утасны дугаар, эмайл хаягийг бичиж авах нь чухал.
- Ямар аргаар (утсаар, эмайл хаягаар, биечлэн уулзах), ямар хэлээр, хэрхэн байнга харилцахаа болон гэнэтийн хэрэгцээ гарсан тохиолдолд хэрхэн цаашдаа харилцах тухайгаа хэлж тохиролцоорой.
- Сургуулиас тантай холбоо барихдаа орчуулагчаар хангаж болно. Сургууль (Үндэсний сурган хүмүүжүүлэх хүрээлэнд хүсэлт гаргаж орчуулагчийг олно).
- **Сурагчийн дэвтэрт žakovská knižka** сурагчдын дүн, чөлөөний хуудас, сургуулиас эцэг эхэд хүргэх чухал мэдээлэлийг (жишээ нь: хичээлийн хуваарийн өөрчлөлт, сургуулийн хөтөлбөрүүд, хүүхдийн хүмүүжилийн доголдлын талаархи асуудал г.м) бичдэг учраас сургууль болон эцэг эхчүүдийн хоорондхи харилцаанд чухал үүрэгтэй. Ихэнх сургуулиуд цахим сурагчийн дэвтэр хэрэглэдэг. (жишээ нь aplíkace Bakaláři)- ийг ашиглаж. Сургууль эхлэхэд танд хэрхэн нэвтрэх талаар заавар өгнө.
- Сургууль дээр тогтмол хугацаанд **ангийн хурал třídní schůzky** болдог- энэ нь эцэг эхчүүдийн багш нартай уулзаж буй уулзалт юм. Энэ хурал дээр хүүхдийн сурлагын талаар мөн сургууль дээр болж буй үйл явдлын талаарх мэдээллийг өгөх учраас сургууль та бүхнээс бүрэн ирцийг хүлээж буй билээ.
- Та бүхэн хүүхэд тань ангидаа дасахгүй байгаад эсвэл ангийнхаа хүүхдүүдтэй харьцааний асуудалтай байгаа үед мөн сургуульд хандаарай.

1 ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙГ ХЭРХЭН ӨНГӨРҮҮЛДЭГ ВЭ? ЧЕХИЙН СУРГУУЛЬ НЬ ХЭРХЭН АНГИЛАГДДАГ ВЭ?

- **Сургуулийн сургалтын školní rok** хугацаа 10 сар үргэлжилдэг, 9 сарын 1-нээс эхлэн дараагийн жилийн 6 сарын 30-нд дуусах ба хоёр **хагас жилд хуваагдана pololeti**. Хүүхдүүдийн дүн хагас жил болгонд гарч хүүхдүүд дүнгийн **гэрчилгээ vysvědčeni** авдаг (хичээл бүрийн дүн гарна).
- Ихэнх сургуулиуд нь өглөө 8 цагт хичээлээ эхэлдэг. Бага ангийн хичээл 4-5 цаг үргэжлэнэ, ахлах ангийн хүүхдүүд зарим тохиолдолд мөн үдээс хойш хичээллэдэг. Хичээлийн шинэ жил эхлэхэд анги бүрийн **хичээлийн хуваарь rozvrh hodin** гардаг. Хичээлийн хуваарь нь хүүхдийн өдөр тутамд ямар хичээлтэй, хир удаан хичээл нь үргэжлэхийг харуулах учраас та хүүхдийнхээ хуваарийн дагуу гэрийн даалгаварыг нь болон дараа өдрийнх нь хэрэгцээт зүйлийг шалгана уу.
- Хичээлийн цаг болгонд 45 минутанд **завсарлагатай přestávka**. Удаан завсарлага бол өглөөний цайнд зориулсан байдаг 9.45-10.00, богино завсарлага нь 5-10 минут буй. Үд дундын завсарлага нь өдрийн хоолны цаг юм.
- Хичээлийн жилийн явцад өвөл ба зуны **амралт prázdniny**, улсын баяр, бусад чөлөөнүүд гэхчилэн чөлөөт өдрүүд тохиолддог буюу энэ өдрүүдэд хүүхдүүд хичээлд явдаггүй учраас эцэг эхчүүд нь хүүхдээ өөрсдөө харж хандах бөгөөд хүүхдүүдийн чөлөөт цагийн арга хэмжээг өөрсдөө зохицуулна.
- Чех сургуулиудад хүүхдийн **дүгнэлт klasifikace** нь жилийн туршид явагдана, энэ нь 1-5 дүнгээр дүгнэгдэнэ (1-онц, 5-муу)
- Хэрэв танай хүүхэд хичээлийн жилийн дүн гарахад ямар нэг хичээлээс 5 (муу) дүнтэй гарвал дахин шалгалт өгөх ёстой, тэр шалгалтандаа тэнцээгүй тохиолдолд улирч, тэр жилээ давтах ёстой.
- Сурагчид сургууль дээрээ дүрэм **сургуулийн дүрэм školní řád** баримтлах ёстой. Хэрэв хүүхэд тань сурагчийн дүрэмийг давтан эсвэл ноцтойгоор зөрчвөл сануулга авах ба захирлын сануулга хүртэх бөгөөд цаашилбал дүнгийн гэрчилгээнд сахилгын дүн нь муугаар бичигдэж болзошгүй.

ЭЦЭГ ЭХ ЯМАР ҮҮРЭГТЭЙ ВЭ?

- **Хүүхэддээ гэртээ хичээлдээ бэлтгэхэд нь domácí příprava** туслах – хүүхэд гэртээ даалгавараа хийж, сургууль дээр сурсан хичээлээ давтаж, шалгалтынхаа бэлтгэлийг хийдэг. Бага ангийн хүүхдүүдэд эцэг эх нь дараагийн өдрийнх нь хичээлийн бэлтгэлд туслах ба мөн бэлтгэлийг нь хянадаг гэж сургууль үздэг. Хэрэв та Чех хэлээр ярьдаггүйгээс хүүхэддээ гэртээ хичээлдээ бэлтгэхэд нь тусалж чадахгүй байвал, **хүүхдээ нэмэлт сургалтад** хамааруулах хүсэлтээ сургуульд гаргаж болно. Хэрэв сургууль дээр нэмэлт сургалт явагддаггүй бол хүүхдээ төлбөртэй сургалтанд хамруулж болохоос гадна та бүхэн Интэграцийн төв болон бусад гадаад иргэдэд туслах байгууллагуудад хандаж сайн дурын багшийн тусламж хүсч болно.
- **Хүүхдийн дүн, сургуультай холбогдсон мэдээллийг байнга хянах** - эцэг эхчүүд нь хүүхдийнхээ хичээлийн дүнгээс гадна хүүхдийнхээ талаарх **дүгнэлтийг známky a prospěch** тогтмол сурагчийн дэвтэрээс, сургуулийн цахим хуудсаас эсвэл ангийн хурлаас олж авна. Сурагчийн дэвтэрт сургуулиас өгч буй мэдээллийг харсан болон ойлгосоноо баталгаажуулж гарын үсгээ зурах юм.
- **Ангийн хуралд оролцох** - эцэг эхчүүд нь сургуулаас зохион байгуулж буй ангийн хурал болон бусад цуглаанд оролцох бөгөөд эдгээр хуралд оролцох боломжгүй тохиолдолд сургуульд энэ байдлыг мэдэгдэж оролцож болох өөр хугацааг тохиролцоно уу.

- Ирцийн **docházka** бүртгэл - хүүхэд тань сургуульдаа явахгүй бол эцэг эх та бүхэн сурагчийн дэвтэрт шалтгаанаа бичин гарын үсгээ зурж заавал сургуульд мэдэгдэх ёстой. Сургуульд ирэхгүй шалтгаан нь эрүүл мэндийн болон гэр бүлийн ноцтой шалтгаанд тулгуурласан байх учиртай юм. Хэрэв таны хүүхэд удаан хугацаагаар хичээлдээ ирээгүй ба та бүхэн хүүхдийнхээ ирэхгүй шалтгааныг сургуульд мэдэгдээгүй байвал сургууль нь зохих байгууллагуудад даруй мэдэгдэнэ. Сургууль нь танай хүүхэд сургуульд ирээгүй байх хугацааныхаа хичээлийг ангийнхаа хүүхдүүдээс эсвэл ангийнхаа багшаас асууж, сонирхож, мэдэж авч түүнийгээ сурч хичээлийн хувьд хоцрохгүй гэж найдаж буй билээ.



ХҮҮХДЭД СУРГУУЛЬД ОРОХОД НЬ ЮУ ХЭРЭГТЭЙ БАЙДАГ ВЭ? ЯМАР ХИЧЭЭЛИЙН ХЭРЭГСЭЛ ŠKOLNÍ POMŮCKY?

- Сургууль болгон сургалтандаа ялгаатай сурах бичиг , материал хэрэглэж болдог. Сургуулиуд номнуудаа **сурах бичигийг učebnice** ихэвчлэн зээлээр хэрэглүүлдэг бөгөөд хичээлийн жилийн төгсгөлд зээлж авсан сурах бичигүүдээ сурагчид нь буцааж өгөх ёстой.
- Бага ангийн сурагчид нь мөн **дасгалын дэвтэр pracovní sešity** гэх нэртэй, дээр нь бичиж болдог дэвтэр хэрэглэдэг ба тэр дэвтэрүүдийг эцэг эх нь худалдаж авах ёстой юм. Түүнээс гадна хүүхдүүд олон төрлийн болон янз бүрийн хэмжээтэй \том-жижиг\ дэвтрэнүүд хэрэглэдэг, тэдгээр дэвтрэийг сургууль нь эцэг эхчүүдтэй тохиролцсоны үндсэн дээр худалдаж авч өгдөг эсвэл эцэг эх нь сургуулийн хүсэлтийн дагуу өөрсдөө худалдаж авдаг юм.
- Өдөр тутамд хэрэглэх сурах бичиг, дэвтэр, ус, зууш, бичгийн хэрэгсэлтэй савыг \үзэг, харандаа, өнгийн харандаа\ хүүхдүүд өдөр болгон цүнхэндээ авч явдаг.
- Мөн хүүхдүүдэд биеийн тамирын хувтас, сургууль дотор өмсөх шаахай, гар урлалд хэрэглэдэг хэрэгсэл \зургийн хичээл\ гэх мэт зүйлс хэрэгтэй байдаг бөгөөд эдгээр зүйлсийг ихэвчлэн ангидаа үлдээж явдаг.
- Сургууль та бүхэнд худалдаж авах ёстой хичээлийн хэрэгсэлийн жагсаалтаас гадна сургуулиас нийлүүлж буй хэрэгсэлд хичнээн крон нэмж төлөх эсэх тухай мэдээллийг олгоно.
- Хүүхдүүдийн хичээлийн хэрэгсэлийн төлбөрөөс гадна эцэг эхчүүд нь багавтар хэмжээний мөнгийг сургуулийн болон ангийн санд хувь нэмэр болгон оруулдаг бөгөөд хуримтлагдсан мөнгийг нэмэж хичээлийн хэрэгсэл авах эсвэл сургууль дээр зохиогдож буй соёлын үйл ажилгааны шагналд гэх мэт зүйлд зарцуулагддаг.
- Дээр дурдсан эцэг эхчүүдийн сургуулийн ба ангийн санд төлж буй мөнгийг нэмэж хичээлийн хэрэгсэл авах эсвэл сургууль дээр зохиогдож буй соёлын үйл ажилгаанд зарцуулах явдал нь мөнхүү улсын үнэ төлбөргүй сургуульд ч завшсан байдаг.



ХЭРХЭН СУРГУУЛЬД ХООЛЛОДОГ ВЭ?

- Эцэг эхчүүд нь ихэвчлэн хүүхдүүдийг **хөнгөн зуушаар svačiny** хангаж, хүүхдүүд өдөр бүр унд болоод савтай зуушаа гэрээсээ авчирдаг.
- Та хүүхэддээ сургуулийн гуанзанд **эдрийн хоолыг obědy** нь захиалж, төлбөрийг нь төлж оруулж болно (ихэвчлэн нэг, хоёр дугаар хоол, жимс, салат, амттан). Хоолны бүртгэлийн хуудас нь сургуулийн бүртгэлийн хуудасны нэг хэсэгт байдаг эсвэл танд сургууль дээр нь хоол захиалахтай холбоотой асуудлыг тайлбарлаж өгдөг.
- Эсвэл хүүхэд тань гэртээ харьж хоолонд орж бас болох юм.



СОНИРХОЛЫН ДУГУЙЛАН ГЭЖ ЮУ ВЭ? ӨДӨР ӨНЖҮҮЛЭХ ХЭРХЭН АЖИЛДАГ ВЭ?

- **Өдөр өнжүүлэх** **školní družina** нь бага ангийн хүүхдүүдэд зориулсан хүүхдийн хичээлээс гадуурхи сургалтын клуб бөгөөд үүнд заавал явах албагүй, эцэг эхчүүд нь төлбөрийг нь төлсөн тохиолдолд хүүхэд явж болдог байна. Хүүхдүүд өдөр өнжүүлэхэд тоглох, даалгавараа хийх, сурах эсвэл гадаа зугаалгаар явдаг бөгөөд түүнчлэн хүүхдүүд нь багш нарын хараа хяналтанд байдаг. Өдөр өнжүүлэхийн багтаамж, хүүхдийн насны хязгаарлал, ажиллах цагийн хуваарь, үнэ өртөг, бүртгүүлэх арга гэх мэт мэдээллийг та сургуулиас авч болно.
- Та сургууль дээр явагдаж буй эсвэл ойролцоох Хүүхэд залуучуудын ордонд явагддаг **дугуйлангуудын жагсаалтыг** сургуулиас асуугаарай. Дугуйлан сонгохдоо та хүүхдийнхээ сонирхолыг (хүүхэд юу сонирхож байх, хүүхдийн хөгжилтөнд нөлөөлөх эсэх) болон төлбөрийг (үнэ төлбөртэй, төлбөргүй) эсвэл хэрэв дугуйланд явахад тусгай хэрэгсэл хэрэгцээтэй (жишээ нь: өндөр үнэтэй спортын хувцас хэрэглэл) эсэхийг харгалзаж үзээрэй.
- Хүүхдүүд хичээлийн жилийн явцад ангитайгаа төрөл **бүрийн соёлын арга хэмжээ**, эсвэл экскурсад оролцдог бөгөөд тэдгээрийн тасалбарыг эцэг эхчүүд нь төлдөг байна. Мөн сургууль нь хүүхдүүддээ **сургуулийн аялал** **školní výlet**, **“Байгаль дахь сургалт”** **škola v přírodě**, эсвэл спортын долоо хоног гэхчилэн арга хэмжээнүүд бэлтгэсэн байдаг. Эцэг, эхчүүд нь хүүхдийнхээ оролцох эсэхийг шийдвэрлэж хүүхдийн байр, хоол, хөтөлбөрийн төлбөрийг төлдөг (сургууль нь эцэг эхчүүдэд хугацаа болон зардалын талаарх мэдээллийг олгоно)
- **Хүүхдийг сонирхлынх нь дагуу дугуйланд** **zájmové kroužky** хамааруулах нь маш чухал юм! Танай хүүхэд ийм дугуйланд хамрагдсанаар хүүхдүүдийн дунд орж найз нөхөдтэй болох мөн ур чадвараа хөгжүүлэхэд нь тустай бөгөөд ялангуяа Чех хэл хурдан сурахад маш их дөхөмтэй байдаг.

Таньд өөр сургуультай холбоотой сонирхох зүйл байна уу? Таньд эцэг эхийн үүрэг нь тодорхой бус байна уу? Сургууль ямар үүрэгтэй вэ? Хүүхдэд тань сургуульд орсоноос хойш ямар нэг проблем илэрч байна уу? Танд сургуультай харилцахад тусламж хэрэгтэй байна уу? Та Интэграчлалын төвийн (CIC) нийгмийн ажилтангуудад хандана уу:

CIC Praha: Pernerova 10/32, Praha 8. Утас.: 704 600 700

CIC Kolín: Zahradní 46, Kolín. Утас.: 774 866 838

CIC Mladá Boleslav: Dukelská 1093, Mladá Boleslav. Утас.: 731 512 726

CIC Kladno: Severní 2952, Kladno. Утас.: 735 173 719

CIC Hořovice: Palackého náměstí 640/34 (Хотын захиргааны 3 давхарт), Hořovice. Утас.: 605 215 649

CIC Mělník: Náměstí Míru 51, Mělník, (Хотын захиргааны 3 давхарт). Утас.: 777 402 129

CIC Liberec: Moskevská 27/14, Liberec. Утас.: 735 752 467

info@cicops.cz

www.cicops.cz



Evropská unie
Evropský sociální fond
Operační program Zaměstnanost

